



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 2 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Жил бүрийн хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч улс эх орон, нийгэм эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байна.

Улсын хэмжээнд 2019 онд нийслэл Улаанбаатар хот, Архангай, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Төв, Увс, Завхан, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Баян-Өлгий, Сүхбаатар зэрэг 15 аймгийн 66 суманд ой, хээрийн түймэр 121 удаа гарч 311.798 га талбай түймэрт өртөж, 13 байшин, 4 гэр шатаж, түймрийн улмаас байгаль экологид 23.756.621.096 мянган төгрөг, түймрийг унтраахад 449.625.850 төгрөгийн зардал гарч, нийт 24.206.246.946 төгрөгийн хохирол учирсан байна.

2019 оны Улсын онцгой комиссын 01 тоот албан даалгаврын хүрээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулснаар ой, хээрийн түймрийн шатсан талбай 2018 онтой харьцуулахад 45.2 хувиар, нийт учирсан хохирол 38.8 хувь буурсан байна.

Цагдаагийн байгууллага 2019 онд 121 удаагийн ой, хээрийн гал түймрийн 22 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 32 мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 53 мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 14 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2020 оны 1 дүгээр сард ирүүлсэн мэдээллээр агаарын температур 2020 оны 1-5 дугаар сард Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод, Завхан зэрэг аймгийн ихэнх нутгаар дундаж орчим, бусад нутгаар 1.0-1.5 градус дулаан байх төлөвтэй байна. Олон жилийн дунджаар Увсын зүүн, Архангайн өмнөд, Булган, Хэнтийн зүүн хойд, Өвөрхангайн хойд, Сэлэнгийн баруун хэсгээр 21-30 мм, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутгаар, Завханы баруун, Өвөрхангайн өмнөд хэсгээр 3-12 мм, бусад нутгаар 12-21 мм хур тунадастай, хаврын улиралд нийт нутгаар хуурайшилтын зэрэг өндөр байх мэдээлэл ирүүлсэн.

Иймд 2020 онд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, гал түймэр унтраах ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг сайжруулах, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цэрэнбатад:

1.1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулахыг;

1.2. Ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр иргэд, ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг сургаж дадлагажуулах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэхийг;

1.3 Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 153 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг;

1.4. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд Цаг уур, орчны шинжилгээний газраас сансрын хиймэл дагуулын мэдээллээр авсан ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг /баяр, амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллахыг;

1.5. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй хуурайшилтын “аюултай”, “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед Цаг уур, орчны шинжилгээний газрын цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг;

1.6. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16 дахь заалтыг хэрэгжүүлэн цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын талаарх мэдээллээр холбогдох байгууллага, хүн амыг хангахыг;

Хоёр. Аймаг, нийслэлийн Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

2.1. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс хамгаалах орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавихыг;

2.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэн нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах тэдгээрийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох зорилгоор зохион байгуулахыг;

2.3. Орон нутагт ой, хээрийн гал түймэр гарсан үед Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтыг хэрэгжүүлэн хүн хүч, техник хэрэгслийг дайчлан тухайн гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах, унтраах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ашиглах, түймрийг унтраахаар ажиллаж байгаа алба хаагчид, иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахыг;

2.4. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.15, 17.2.21 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй газар нутагт түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зурвас шинээр байгуулах, зурвасыг сэргээх, ой, хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах хүн хүч, техник хэрэгслийг тооцон, тэдгээрийг гал түймэр унтраах багаж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулахыг;

2.5. Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг мөрдөж ажиллахыг;

2.6. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалтыг хэрэгжүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга нар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хөрөнгө төсөвлөж, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэстэй хамтран ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тусгахыг;

2.7. Ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрч 14 хоногоос дээш хугацаагаар ажиллаж, аймаг, нийслэлээс нэмэлт хүн, хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмнэлгийн баг томилон ажиллуулахыг;

2.8. Засаг дарга нар 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18 дахь заалтын дагуу ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах, хориглох захирамж гарган, хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчилахыг;

2.9. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.19 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг бууруулах, арилгах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхийг;

2.10. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тогтоох ажлыг түймэр унтарснаас хойш 30 хоногийн дотор зохион байгуулахыг;

Гурав. Батлан хамгаалахын сайд,
Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболдод:

3.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгсэл хүрэлцэн очих боломжгүй алслагдсан ой, хээрийн бүсэд гарсан гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд нисдэг тэрэг ашиглан бие бүрэлдэхүүнийг шуурхай хүргэхийг;

3.2. Төв, орон нутгийн Зэвсэгт хүчний анги, байгууллагын бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр Онцгой байдлын газар, хэлтэстэй хамтран хичээл, сургалт, дадлагын ажлыг зохион байгуулж, шаардлагатай техник, багаж хэрэгслээр хангахыг;

3.3. Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалтыг хэрэгжүүлэн зэвсэгт хүчний алба хаагчдыг ой, хээрийн гал түймэр унтраах ажилд оролцуулах, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, багаж хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахыг;

Дөрөв. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
хошууч генерал Т.Бадралд:

4.1. Орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, урьдчилан сэргийлэх, унтраах, сургалт сурталчилгаа зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээд, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулахыг;

4.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн нийт бие бүрэлдэхүүний ой,

хээрийн гал түймэр унтраах, автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусгай хувцасны бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахыг;

4.3. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн иргэдийг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж шаардлагатай тохиолдолд дайчилгаа явуулахыг;

4.4. Ой, хээрийн гал түймрийн голомтод удаан хугацаагаар ажилласан үед албан хаагчдын өдөр тутмын болон хөдөлмөр хамгааллын хувцасны нөхөн хангалт хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулахыг;

4.5. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, гал түймрийн улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг;

4.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан танилцуулж, шаардлагатай төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж тайланд тусгахыг;

Тав. Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
хилийн цэргийн командлагч, Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэнд:

5.1. Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр сургалт зохион явуулж, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, багаж хэрэгслээр хангахыг;

5.2. Монгол улсын хил орчим гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд шуурхай мэдээлж, хамтран ажиллах, гарсан гал түймрийг цаг алдалгүй унтраах, арга хэмжээг зохион байгуулах, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулахыг;

5.3. Монгол Улсын хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээх орнуудын хил дамнан гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг таслан зогсоох, үйл ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот албан хаагч, иргэдийг хярбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг;

5.4. Хил дамнан орж ирсэн болон хил давж гарсан ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээллийг тухай бүр Улсын онцгой комисст болон Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлж баримтжуулахыг;

Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
бригадын генерал С.Баатаржавт:

6.1. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэн ажиллахыг;


6.2. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн хэргийн эзэн холбогдогч, шалтгаан нөхцөлийг шалган тогтоож, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч энэ тухай мэдээллийг улирал бүр Улсын онцгой комисст ирүүлэхийг;

6.3. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэн дагуу ой, хээрийн түймрийн аюултай үед ойд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөнийг хориглохыг;

6.4. Ой, хээрийн гал түймрийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагатай хамтран мэдээ, мэдээллийг харилцан шуурхай солилцож, хамтран ажиллахыг тус тус даалгаж байна.

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын ажлын албанд 2020 оны 06 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус ирүүлэхийг холбогдох комиссын гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН